

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК

Огноо: 2019.07.25



**АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/
гэрээний нэр:

**АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ
ХУДАЛДАН АВАХ**

**ТӨСЛИЙН ДУГААР № ДҮТ-2019-02-07
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР № ДҮТ/201902007**

**Улаанбаатар хот
2019 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ДҮТ ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Ажлын хэрэгцээнд тавилга, эд хогшил** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019.08.02-ны 10:00 цагаас** өмнө www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019.08.02-ны өдрийн 10 :30 цаг** -т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3- хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын байр 14-р байр, Диспетчерийн үндэсний төв ХХК (№ 416 өрөө, С.Мандахтөр 70041104 , факс - 70043467)

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**





ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. Татварын тодорхойлолт / өргүй байх/ 3. Сүүлийн 1 жилийн баталгаажсан санхүүгийн тайлан 4. Сүүлийн 2 жилийн буюу 2018,2019 оны туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт/; 5. Борлуулалтын хэмжээ: 50 / тавин / сая, сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны аль нэг жил 6. Үнийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. /Маягт № ТШМ-2А,Б,В-ийг тохирохыг сонгох/ 7. Барааны жагсаалт болон бараа нийлүүлэх хуваарь /маягтын дагуу мөн баталгаажуулсан байх/ 8. Нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт ирүүлэх 9. Баталгаат засварын хугацаа 6 сараас 1 жил хүртэл хугацаатай байна
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: www.tender.gov.mn цахим хуудас, Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын 14-р байр, Диспетчерийн үндэсний төв ХХК, 4-р давхар № 416 тоот Утас: 70041104 Факс: 70043467</p> <p>Огноо: 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: www.tender.gov.mn цахим хуудас Байгууллагын хаяг Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын 14-р байр, Диспетчерийн үндэсний төв ХХК, 4-р давхар № 416 тоот</p> <p>Огноо: 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдөр</p> <p>Цаг: : 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. [Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийг жагсаан бичих] 2. ...
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>




Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**


АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД ТАВИЛГА, ЭД ХОГШИЛД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

БАТЛАВ.
 ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
 БӨГӨӨД ЕРӨНХИЙ ДИСПЕТЧЕР
 Б. БААТАР

2019 ОНД ХУДАЛДАН АВАХ ТАВИЛГА, ЭД ХОГШИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Нэр, төрөл	ш	Тоо	Зориулалт	Хэмжээ	Шаардлага	Өнгө	Загвар
1	Удирдлагын ширээ	ш	2	Удирдлагын ерөний зориулалттай	200*205/90*75	Ширээний тавцангийн болон хөлний хавтан нь шахалт нягтрал сайтай.	Худалдан авахдаа өнгийг сонгох боломжтой байх	
2	Тумбочка	ш	6	Албан тасалгааны зориулалттай	40x60x75	Ширээнээс салдаг, дугуйтай, цоожтой, хавтан нь шахалт нягтрал сайтай.	<ul style="list-style-type: none"> • 2ш - удирдлагын ширээтэй хосолсон өнгөтэй, • 2ш – улбар шар /өнгийг зургаар харуулав/ • 2ш - худалдан авахдаа өнгийг сонгох боломжтой байх 	
3	Туслах шүүгээ	ш	2	Албан тасалгааны зориулалттай	80x43x75	Цоожтой, хавтангийн шахалтын нягтрал сайтай.	Удирдлагын ширээнүүдтэй адил өнгөтэй, хосолсон загвар хийцтэй байх	
4	Уулзалтын дугуй ширээ	ш	1	Албан тасалгааны зориулалттай	120x120x75	Дугуй хэлбэртэй, Ширээний тавцангийн болон хөлний хавтан нь шахалт нягтрал сайтай.	Удирдлагын ширээтэй хосолсон өнгөтэй /худалдан авахдаа өнгийг сонгох боломжтой байх/	

5	Ажлын сандал	ш	13	Албан тасалгааны зориулалттай		<p>Эргэдэг, дугуйтай, гарын давуун бүрээстэй, түшлэг нэлэлтийн механизмтай, хазайлтыг түгждэг, даац сайтай.</p> <p>Эргэдэг, дугуйтай, гарын тавиуртай, савхин болон давуун бүрээстэй, түшлэг өндөр, нэлэлтийн механизмтай, хазайлтыг түгждэг, даац сайтай.</p>	<p>Хар өнгөтэй /худалдан авахдаа загварыг сонгох боломжтой байх/</p> <p>Хар өнгөтэй /худалдан авахдаа загварыг сонгох боломжтой байх/</p>	
6	Буйдан /2-3 хүний суудалтай/	ш	2	Албан тасалгааны зориулалттай	150 см-ээс дээш урттай	<p>2-3 хүний суудалтай, савхин бүрээстэй</p>	<p>Хар, саарал өнгөтэй. /худалдан авахдаа өнгийг сонгох боломжтой байх/</p>	
7	Номын шүүгээ /модон/	ш	5	Албан тасалгааны зориулалттай	80x180x45	<p>Модон материалтай, хавтангийн шахалтын нягтрал сайтай, 4 хаалгатай, Дээд 2 хаалга нь шилэн материалтай, цоожтой. Доод 2 хаалга нь модон материалтай, цоожтой.</p> <p>Хувцасны шүүгээ нь хамт байж болно.</p>	<p>2ш - Удирдлагын тавилгатай хосолсон өнгөтэй, 1ш –цайвар шаргал өнгөтэй, 1ш-улбар шар өнгөтэй /өнгийг зургаар харуулав/ 1ш – худалдан авахдаа өнгийг сонгох боломжтой байх</p>	
	Номын шүүгээ /төмөр/	ш	1	Албан тасалгааны зориулалттай	80x180x45	<p>Төмөр, 4 хаалгатай, цоожтой, төмрийн зузаан нь 0,6мм-ээс доошгүй.</p>	<p>Саарал өнгөтэй</p>	

8	Хувцасны шүүгээ	Ш	5	Албан тасалгааны зориулалттай	40x180x45 80x180x45	Модон материалтай, хавтангийн шахалтын нягтрал сайтай, дотроо малгай, гутлын тасалгаатай.	<ul style="list-style-type: none"> • 2ш - удирдлагын тавилгатай хосолсон өнгөтэй, • 2ш – улбар шар /зургаар өнгийг харуулав/ • 1ш – худалдан авахдаа өнгийг сонгох боломжтой байх 	
---	-----------------	---	---	-------------------------------	------------------------	-------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------

Нэмэлт шаардлага:

Тендерт шалгарсан компани нь Улаанбаатар хотод тавилгын дэлгүүртэй байх ба төсөвт өртөгт багтаан өнгө, загварын сонголт хийх, өөрчлөх боломжтой байх.

Хянасан:



СЭЗХ-ийн дарга

А.Цагаансар

Боловсруулсан:



Эдийн засагч

Д.Байгалмаа

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|----------------------------------------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Нийлүүлэгч бүтээгдэхүүндээ чанарын баталгаа өгнө. Хэрвээ бүтээгдэхүүний чанар стандартын шаардлагыг хангаагүйгээс үүссэн хохирлыг нийлүүлэгч бүрэн барагдуулна.</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн 50 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: 0.05 %</p> <p>Алдангийн нийт дүн: 10 %</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

Ажлын хэрэгцээнд тавилга, эд хогшил худалдах, худалдан авах гэрээ.

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас **Диспетчерийн үндэсний төв ХХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[Ажлын хэрэгцээнд тавилга, эд хогшил]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь Ажлын хэрэгцээнд тавилга, эд хогшил нийлүүлэх нэр төрлийн барааг 2018 оны __ дугаар сарын ____ -наас 2019 оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]